



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ГСА дахь Төрийн аудитын газрын
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг:
sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг:
Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Батсайхан
Утас: 70543151
Цахим хаяг:
batsaikhants@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ГСА, Сүмбэр сум 3-р
баг, Нутгийн удирдлагын ордон

Байршил: Нутгийн удирдлагын ордон
2 давхар 208 тоот

Цахим хуудас:
www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Нэг. Ерөнхий зүйл	
Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	5
Аудитын арга зүй.....	5
Материаллаг байдлыг тодорхойлох	6
ОН-ийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....	6
Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь	6
Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж	6
Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн	6
Хоёр. Санхүүгийн дотоод хяналт	7
Гурав. Шилэн дансны мэдээлэл.....	8
Дөрөв. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	9
4.1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	10
4.1.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар	10
4.1.2. Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар	11
4.1.3. Орон нутгийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар	12
Тав. Авлага, урьдчилгааны бүртгэл, тайлагнал.....	13
5.1. Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар.....	13
5.2. Авлагын үлдэгдэл, тооцоо нийлэлтийн талаар	14
5.2.1 Төсөвт байгууллага, төсөл сангийн авлагын талаар	14
5.2.2 ОНӨААТҮГ-ын авлагын талаар	15
5.3 Урьдчилгааны талаар	15
5.4 Орон нутгийн ТЭЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	16
Зургаа. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
6.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар	16
6.2 Бусад эргэлтийн хөрөнгийн талаар	17
6.3 ОНТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар	17
Долоо. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
7.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар	18
7.2 Орон нутгийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар	19
Найм. Өр төлбөрийн бүртгэл тайлагнал	
8.1. Өр төлбөрийн бүтцийн талаар	20
8.2. Өглөгийн үлдэгдэл, тооцоо нийлэлтийн талаар	21
8.2.1 Төсөвт байгууллагын өглөгийн талаар	21
8.2.2 Төсөл, сангийн өглөгийн талаар	22

8.2.3 ОНӨААТҮГ-ын өглөгийн талаар	22
8.3 Урт хугацаат зээлийн талаар	22
8.4 Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар	23
Ес. Орлогын бүртгэл тайлагнал	23
9.1 Орон нутгийн ТЕЗ-ын 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар	23
9.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар.....	24
9.3 Бусад эх үүсвэрийн талаар	25
Арав. Зардлын бүртгэл, тайлагнал.....	27
10.1 Санхүүжилтийн зарцуулалтын талаар	27
10.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар	28
10.3 Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар.....	29
Арван нэг. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар	29
Арван хоёр. Хуримтлагдсан үр дүнгийн талаар.....	30
Арван гурав. Эзэмшигчийн өмчийн талаар	30
13.1 Орон нутгийн эзэмшигчийн өмчийн талаар	30
13.2 Дахин үнэлгээний нөөцийн талаар	31
Арван дөрөв: Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн	31
14.1 Төсвийн төвлөрүүлсэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	31
14.2 Орон нутгийн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	31
14.3 Тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	32
14.4 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	32
Арван тав. Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	32
Арван зургаа. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....	33
Арван долоо. Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт.....	33

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АЗДНС	Аймгийн Засаг даргын нөөцийн сан
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АОУС	Аудитын олон улсын стандарт
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар
БХЯ	Батлан хамгаалах яам
БСГ	Боловсрол, соёлын газар
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинэжлэх ухаан, спортын яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНТЕЗ	Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн ОУС
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХО	Хөрөнгө оруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

АУДИТЫН ТАЛААРХИ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, 18 дугаар зүйлийн 18.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд /ГСА-/2018/01-СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг бүрэн ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт болно.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь ОНТЕЗ-ийн 2017 оны төсвийн жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл хөтөлбөр, сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргалаа.

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТТЗ-ийн 3, төсвийн шууд захирагчийн 14, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 20, тусгай сангийн 16, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 5, нийт 58 санхүүгийн тайлан, орон нутгийн нөөц хөрөнгө, автозамын сан, сум хөгжүүлэх сан, ахмадын байгууллагын санхүүгийн дэмжлэг, мал эмнэлгийн үйлчилгээ, ахмадын нэгдсэн сан, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансдын зардлын гүйлгээг хамрууллаа.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна” гэж заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг 100% хамруулсан байна.

Аудитын арга зүй

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж

авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Материаллаг байдлыг тодорхойлох

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 1.0%-иар тооцон 186.6 сая төгрөгөөр тогтоов.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

ТЕЗ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалтын дагуу 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргаж, хуульд заасан хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг баримтлан, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д заасны дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллага хооронд үүссэн 16,571.1 сая төгрөгийн давхардсан ажил гүйлгээ, орлого болон зардлыг цэвэрлэж тайлагнасан,
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллага, төсөл, хөтөлбөр, сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан,

тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Мөн Сангийн яамнаас “Э-тайлан” програм системийг хөгжүүлж, тус програмаар орон нутгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ТЕЗ-ийн санхүүгийн тайланг нэгтгэснээр цэвэрлэх бичилтийн хамрах хүрээг нэмэгдүүлж чадсан, бүх шатны төсвийн байгууллагуудын тайланг хамруулсан өгөгдлийн нэг баазтай болсон, интернетийн орчинд ажилладаг, хяналт, аудит хийх нөхцөлийг нэмэгдүүлж өгсөн давуу талтай байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Үндсэн хөрөнгө, бараа материал, өр, авлагын тодруулга тайлан байгууллагын төрлөөр
ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
ОН-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
ОН-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	

ХОЁР. САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ

Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагч 2017 онд санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, журмыг баримтлан ажилласан байна. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.10-т заасны дагуу ТЕЗ нар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар ТЕЗ бүр дотоод аудитын алба байгуулж ажиллах тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба” 2015 онд аймгийн ЗДТГ-ын бүтцэд байгуулагдсан бөгөөд 2017 онд нийт 18 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгаж, 84.9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлж, 20.2 сая төгрөгийн акт бичиж, зөрчил дутагдлыг арилгуулахаар 15 байгууллагад зөвлөмж, 19 албан шаардлага өгч ажилласан байна.

Тухайн тайлант хугацаанд хийгдсэн хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Албан томилолтын хоногийг засаж, илүү дутуу олгосон, анхан шатны баримтын бүрдлийг хангадаггүй /Засгийн газрын 218-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан журмын 12-р заалт/
- Автомашины шатахууны зарцуулалтыг тооцохдоо нормоос илүү бодож олгосон ба замын хуудсыг бөглөдөггүй /Дэд бүтцийн сайдын 2004оны 19-р тушаалаар баталсан жишиг норм /

- Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны хувьд зарим байгууллага нь дотоод хяналтыг огт хийдэггүй, зарим байгууллага нь хяналт шалгалт хийсэн боловч шаардлага хангахгүй санхүүгийн үйл ажиллагаандаа бус үндсэн үйл ажиллагаандаа хяналтыг хэрэгжүүлдэг /ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол /
- Удирдлагууд хүчингүй болсон хууль тогтоомжийг тушаал шийдвэрийн үндэслэл болгосон
- Ажлаас халагдсан ажилтнуудтай ээлжийн амралтын тооцоо хийдэггүйгээс ээлжийн амралтын олговор дутуу олгодог, мөн ээлжийн амралтын мөнгийг давхардуулан тооцож олгосон /Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1 дэх заалт/
- Ажилчдад цалингийн урьдчилгаа бодож олгохдоо цалингаас давсан хэмжээгээр олгодог боловч тухайн сард цалин хүрэлцэхгүй бол өглөг, авлагаар тусгадаггүйгээс ажилчдаас авах авлага дутуу суутгах /НББТХ-ийн 14.4.2 дахь заалт/
- ХЭДС-гийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олгож буй зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьдаггүй, зээл нь хугацаандаа төлөгдөөгүй иргэдэд ямар нэг хариуцлага тооцдоггүй
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, үндсэн хөрөнгөө коджуулаагүй, элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох газарт нь санал хүргүүлж шийдвэрлүүлдэггүй /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 зүйл /
- Шагнал урамшуулал олгохдоо ХХОАТ суутгадаггүй /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 16.1.1, 23.1, 26.1.1 дэх заалтууд/

Дээрх зөрчлүүдийн улмаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, холбогдох журам, зааврууд зөрчигдсөөр байна.

Төсвийн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй, алдаа зөрчлийг давтсаар байгаа нь дотоод аудитын алба харьяа байгууллагуудынхаа санхүүгийн үйл ажиллагааг шалгах, зөрчлийг илрүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах зэрэг үйл ажиллагаа хангалтгүй, сургалт мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна.

ГУРАВ. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулинд төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан байна.

ОНТЕЗ-ийн харьяа байгууллагууд хуулинд заасан дээрх мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж байгаа бөгөөд хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллага, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт тавьж ажилласан байна.

СХАА-наас 2017 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит

үйлдвэрийн газар, сан зэрэг нийт 75 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтанд тогтмол хяналт тавьж ажилласан байна.

Тус хяналтаар давхардсан тоогоор 55 байгууллагад албан тоот хүргүүлж, шилэн дансанд оруулбал зохих мэдээллийг нөхөн оруулуулж, 14 байгууллагад шилэн дансны мэдээ оруулалттай холбоотой хугацаатай албан шаардлага хүргүүлжээ. Албан шаардлагын биелэлт 100.0%-тай байна. Шилэн дансны мэдээ оруулалтанд тогтмол хяналт тавьснаар байгууллагууд мэдээ тайлангаа илгээдэггүй байсан бол 3 улирлын байдлаар 100.0% илгээсэн байна.

Мөн шилэн дансны цахим хуудасны мэдээ оруулалтын хугацаа хэтрэлт өмнөх онд 35.9% байсан бол энэ онд 15.0% болж 20.9%-иар бууржээ. Энэ нь шилэн дансны мэдээ оруулалтын чанар сайжирсныг харуулж байна.

Мөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж сар бүрийн 15-нд аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга болон Санхүү, төрийн сангийн хэлтсийг мэдээллээр ханган ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараахь нийтлэг дутагдал илэрсэн байна.

- Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбар бичдэггүй /ШДТХ-ийн 6.3.3 заалт/
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт байхад хийдэггүй. /ШДТХ-ийн 6.4.1 заалт/
- Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэж заасны дагуу мэдээ тайланг хугацаанд нь илгээдэггүй зөрчил нийтлэг илэрсэн. /Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт/ Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах, байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнуудыг нэгдсэн нэг ойлголттой болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

ДӨРӨВ. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТТЗ, орон нутгийн төсөвт байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллага, төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл, сангуудын нийт 58 байгууллагын тайланг хамрууллаа.

Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсарч ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх.” гэж заасны дагуу ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад хугацаанд нь ирүүлсэн болно.

4.1. МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

4.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын нярвын данс, харилцах дансдын үлдэгдэл
- Төсөл, сангийн үлдэгдэл
- ОНӨААТҮГ-уудын харилцах дансны үлдэгдэл
- ОНӨААТҮГ-уудын кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эцэст 2,183.1 сая төгрөг байсан ба тайлант оны эцэст 2,873.3 сая төгрөг болж 31.6% буюу 690.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт үлдэгдлийн 79.3% нь төрийн сангийн нэгдсэн дансанд, 0.2% нь аж ахуй нэгжийн касс, 20.5% нь арилжааны банкинд байршиж байна.

ОНТЕЗ-ийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө					
Төгрөг/ЖМС	1.4	4.8	4.8		
Касс					
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,181.7	2,868.5		588.6	2,279.7
Төгрөг	2,181.7	2,868.5		588.6	2,279.7
Гадаад валют					-
Замд яваа мөнгөн хөрөнгө					-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,183.1	2,873.3	4.8	588.6	2,279.7
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	1,005.4	1,040.5		0.3	1,040.2
Төсөвт байгууллагууд	898.4	1,337.1		492.3	844.8
ОНӨААТҮГ	50.9	100.8	4.8	96.0	0
Төсөл, сангууд	228.4	394.9			394.7
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,183.1	2,873.3	4.8	588.6	2,279.7

Хүснэгтээс харахад: Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь өмнөх оноос нийт 690.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төрийн сан дахь дансдын үлдэгдэл 35.1 сая, төсөвт байгууллагын үлдэгдэл 438.7 сая, төсөл сангийн үлдэгдэл 166.5 сая, ОНӨААТҮГ-уудын үлдэгдэл 49.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр нь авч үзвэл:

- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.040.5 сая төгрөгөөс 145.9 сая төгрөг нь сумдын давсан орлого, 618.1 сая төгрөг нь аймгийн давсан орлого, 164.5 сая төгрөг Халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл, 112.0 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн үлдэгдэл тус тус байна.
- Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,337.1 сая төгрөгөөс 587.6 сая төгрөг нь аймгийн ОНХС, 88.1 сая төгрөг нь сумдын ОНХС, 0.2 сая төгрөг нь сумдын Мал хамаалах сан, 165.7 сая төгрөг нь сумдын Сум хөгжүүлэх сан, 492.3 сая төгрөг нь Цөм сүргийн үржлийн төвийн, 3.2 сая төгрөг нь сумдын Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл тус тус байна.
- Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 394.6 сая төгрөгөөс 233.9 сая төгрөг нь аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа, 109.8 сая төгрөг нь сумдын хөрөнгө оруулалтын барьцаа, 51.2 сая төгрөг нь Ахмадын нэгдсэн сангийн үлдэгдэл тус тус байна.
- ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 100.8 сая төгрөг байгаагийн 47.8 сая төгрөг нь “Ус-Ду” ОНӨААТҮГ, 20.1 сая төгрөг нь “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ, 32.9 сая төгрөг “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын үлдэгдэл тус тус байна.

4.1.2 Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар

Төсвийн тухай хуулийн дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад сумдын орон нутгийн орлогын дансууд үлдэгдэлгүй, харин аймгийн орон нутгийн орлогын данс 0.3 сая, Халамжийн сангийн данс 0.2 сая, ОНӨААТҮГ-уудын данс 588.1 сая төгрөг, нийт 588.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансны үлдэгдлийг хураангуйлан харуулбал:

(сая төгрөгөөр)

АЙМАГ	ҮЛДЭГДЭЛ									НИЙТ ҮЛДЭГДЭЛ /сая.төг/	НИЙТ ДАНСНЫ ТОО
	Бэлэн мөнгөний касс	Жижиг мөнгөн сан	Зөвшөөрөлгүй	ОН-ийн орлого	ОН-ийн халамж	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар	Төсөвт байгууллага	Төсөл сан	Хаагдсан		
Говьсүмбэр		-	-	0.3	0.2	588.1		-	-	588.6	17
НИЙТ ДҮН	0	0	0	0.3	0.2	588.1		0	0	588.6	17

Арилжааны банкин дахь үлдэгдэл нь орон нутгийн татварын орлогын үлдэгдэл байгаа бөгөөд үлдэгдлийн 93.3% буюу 549.5 сая төгрөг нь Төрийн банкинд, 5.6% буюу 32.7 сая төгрөг нь ХААН банкинд, 1% буюу 5.6 сая төгрөг Хас банкинд, 0.1% буюу 0.8 сая төгрөг Капитал банкинд тус тус байршиж байна.

Эдгээр орлогын үлдэгдэл нь Төрийн сан 4 цагаас гүйлгээ хаадагтай холбоотой бөгөөд банкууд үлдэгдлийн тохируулга хийдэггүй, өөрийн үлдэгдлээр тайлагнаж, төсөвт орлого хүлээн зөвшөөрч бүртгэх боломжгүй байна.

4.1.3. Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар

Орон нутгийн ТЕЗ-ын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, зарцуулалттай холбоотой нийт **1,481.6** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **1,175.1** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **13.7** сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, **2.4** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **290.4** сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 86% буюу **1,278.5** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 14% буюу **203.1** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Халамжийн сангийн төсвийг үндэслэлгүй өндөр төлөвлөснөөс өмнөх онд 281.8 сая, тайлант онд 164.3 сая төгрөгийн хэмнэлт үүсч төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

- Арилжааны банк болон аймаг, сумдын төрийн сангийн ажлын уялдаа холбоо муугаас арилжааны банкаар дамжуулан цалингийн гүйлгээг хийхдээ төрийн сангаар хянуулсан тэмдэглэгээтэй цалингийн жагсаалтыг өөрчлөн төсвийн хөрөнгийг шамшигдуулах, хувьдаа завших зөрчил дутагдал давтагдан гарсаар байна. Түүнчлэн төсөвт байгууллагуудын арилжааны банкин дахь бэлэн мөнгөний харилцах дансанд /жижиг мөнгөн сангийн данс/ төрийн сангаас хэрэгжүүлэх хяналт сул байгаагаас холбогдох журмыг зөрчин орлого төвлөрүүлж, зориулалт бусаар зарцуулсан зөрчил дутагдал илэрсэн. Мөн төсөвт байгууллагын нягтлан бодогч нар татвар, нийгмийн даатгалын тайланд цалингийн мэдээллийг буруу тайлагнадаг алдаа, зөрчил нийтлэг гарч байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.13-т “эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

- Аймгийн Баяр наадмыг тэмдэглэхэд АОНХС-гаас 20.0 сая, АЗДНС-гаас 21.5 сая, нийт 41.5 сая төгрөгийг зарцуулж, арга хэмжээний зардлыг 31.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Улсын баяр наадмыг зохион байгуулах зардалд МУЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль эрхийн актаар тогтоосон хэм хэмжээг баримтлан ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 2018 оны төсөв, төлөвлөгөө батлахтай холбоотойгоор ИТХТ-ийг хүлээн авч уулзалт зохион байгуулахад 2.0 сая аймагт Өмгөөлөх алба байгуулагдсаны 25 жилийн ойн баярыг тэмдэглэхэд дэмжлэг 0.3 сая, Монголын ҮЭ-ийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг 5.0 сая, нийт 7.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль эрхийн актаар тогтоосон хэм хэмжээг баримтлан ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

ТАВ. АВЛАГА, УРЬДЧИЛГААНЫ БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын эхний үлдэгдэл 1,519.4 сая төгрөг байсан бол тайлант онд 8.9% буюу 136.3 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 1,655.7 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	6.6	3.7	-2.9	-43.9
Байгууллагаас авах авлага	1,161.9	1,292.2	130.3	11.2
Хувь хүмүүсээс авах авлага	350.9	359.8	8.9	2.5
НИЙТ ДҮН	1,519.4	1,655.7	136.3	-30.2
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	0.0	0.0	0.0	0.0
Төсвийн байгууллага	1,392.3	1,507.0	114.7	91.0
Төсөл, сан	0.0	0.0	0.0	0.0
ОНӨААТҮГ-ууд	127.1	148.7	21.6	9.0
НИЙТ ДҮН	1,519.4	1,655.7	136.3	100.0

Хүснэгтээс харахад: Нийт авлагын 78%-ийг байгууллагаас авах авлага, 0.2%-ийг хувь хүмүүсээс авах авлага, 21.8%-ийг ажиллагчидтай холбоотой авлага эзэлж байна.

Нийт авлагын 91% нь төсөвт байгууллагын, 9% нь ОНӨААТҮГ-ын авлага байна.

Авлагын эцсийн үлдэгдэл өмнөх оноос нийт дүнгээрээ 30.2%-иар өссөн бөгөөд дансны нэр, төрлөөр нь авч үзвэл хувь хүмүүсээс авах авлага болон байгууллагаас авах авлага 2.5-11.2%-иар нэмэгдэж, ажиллагчидтай холбогдсон авлага 43.9%-иар буурсан байна.


Авлагыг аймаг, сумдаар нь дараах хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Аймаг, сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
Аймаг	184.8	227.2	42.4	22.9	13.7
Сүмбэр сум	986.2	908.9	-77.3	-7.8	54.9
Баянтал сум	172.9	346.4	173.5	100.3	20.9
Шивээговь сум	175.5	173.2	-2.3	-1.3	10.5
НИЙТ ДҮН	1,519.4	1,655.7	136.3	114.1	100.0

Хүснэгтээс харахад: Шивээговь сумын авлага 1.3%, Сүмбэр сумын авлага 7.8%-иар тус тус буурч, Баянтал сумын авлага 100.3%, аймгийн авлага 22.9%-иар тус тус нэмэгдсэн байна.

Нийт авлагад аймаг, сумдын авлагын эзлэх хувийг диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: Нийт авлагын 13.7%-ийг аймаг, 54.9%-ийг Сүмбэр сум, 20.9%-ийг Баянтал сум, 10.5%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

5.2 Авлагын үлдэгдэл, тооцоо нийлэлтийн талаар

5.2.1 Төсөвт байгууллага, төсөл сангийн авлагыг тодруулбал:

Төсөвт байгууллагын авлага 1,507.0 сая төгрөгөөр тайлагнагдсаны 2.3% буюу 34.4 сая төгрөг нь орон нутгийн байгууллагын, 1.8% буюу 27.8 сая төгрөг нь тусгай шилжүүлгийн байгууллагын, 15.8% буюу 238.6 сая төгрөг нь ОНХС-гийн, 79.9% буюу 1,203.7 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 0.2% буюу 2.5 сая төгрөг нь Мал хамгаалах сангийн авлага байна.

Орон нутгийн байгууллагын 34.4 сая төгрөгийн авлага нь 10 байгууллагын, тусгай шилжүүлгийн байгууллагын 27.8 сая төгрөг нь 14 байгууллагаас авах авлага байна.

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулах үйл ажиллагаа хангалтгүй, ямар байгууллага, хувь хүнээс авах нь тодорхойгүй байдал хэвээр байсаар байна.

Төсвийн шууд захирагчид авлагатай ажиллаж байгаа нь “Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйг харуулж байна. Аудитаас төсөв захирагч бүрд авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажилласан болно.

Эдгээр авлагыг барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлж байсан ч зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээ авдаггүй, анхаардаггүй байсаар өнөөг хүргэсэн бөгөөд энэ жилийн тайланд мөн барагдаагүй, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн авлага нь өмнөх онуудад санхүүжилтийн урьдчилгаа аваад гэрээний хугацаанд ажлаа хийгээгүй орхисон газруудтай холбоотой үүссэн он дамжин хуримтлагдсан авлагууд байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүн өмнөх оноос 88.1 сая төгрөгөөр буурсан байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагын 73% буюу 878.6 сая төгрөг нь Сүмбэр сум, 14.1% буюу 170.3 сая төгрөг нь Шивээговь сум, 12.9% буюу 154.8 сая төгрөг нь Баянтал сум тус тус эзэлж байна.

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсөл сангийн авлагын судалгаанаас үзэхэд авлагыг барагдуулах ажил удаашралтай, дорвитой арга хэмжээ авч, санал санаачлага гаргахгүй байгаагаас авлага он дамжин хадгалагдаж, насжилт нэмэгдэн улмаар төлөгдөх найдваргүй болох нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

Иймд аудитаас сумдын СХС-ийн орлогын төлөвлөгөөний биелэлт, зээлийн эргэн төлөлтөнд анхаарч, тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах талаар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

5.2.2 ОНӨААТҮГ-ын авлагыг тодруулбал:

ОНӨААТҮГ-ын авлага өмнөх онд 127.1 сая төгрөг байсан бол 2017 онд 148.7 сая төгрөг болж 21.6 сая төгрөгөөр өссөн байна.

5.3 Урьдчилгааны талаар

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 35.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 372.6 сая төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 336.7 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт урьдчилгаа дансны 95% буюу 352.0 сая төгрөг нь урьдчилж гарсан зардал байна.

Энэ нь аймгийн Автозамын сангаас хийсэн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээлгэн өгөөгүйгээс 16.0 сая төгрөг, тайлант онд Цөм сүргийн үржлийн төв төсөл

хэрэгжүүлж хонь худалдан авч холбогдох шийдвэр нь гараагүйгээс тус тус урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.

Урьдчилж гарсан зардлын 94.5% буюу 352.0 сая төгрөг нь аймгийн, 3.9% буюу 14.7 сая төгрөг нь Шивээговь сум, 1.6% буюу 5.9 сая төгрөг нь Баянтал сум тус тус эзэлж байна.

Урьдчилгаа дансыг байгууллагын төрлөөр авч үзвэл, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урьдчилгаа 336.0 сая, төсөвт байгууллагын урьдчилгаа 20.6 сая төгрөг, орон нутгийн сангийн 16.0 сая төгрөг байна.

5.4 Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлага, урьдчилгааны бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагатай холбоотой **141.2** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс аудитын явцад **23.8** сая төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **12.6** сая төгрөгийн зөрчил дутагдал арилгуулах албан шаардлага хүргүүлж, **104.8** сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгөв.

ЗУРГАА. БАРАА МАТЕРИАЛ, БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

6.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл 1,576.8 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,087.8 сая төгрөг болж тайлант онд бараа материалын үлдэгдэл 32.4%-иар буюу 511.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

(сая.төгрөгөөр)				
Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	177.3	195.8	18.5	10.4
Эм боох материал	10.9	13.3	2.4	22.0
Дуусаагүй үйлдвэрлэл			0.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0.0		0.0	0.0
Бичиг хэргийн материал	26.9	37.1	10.2	37.9
Аж ахуйн материал	625.2	703.0	77.8	12.4
Сэлбэг хэрэгсэл	35.5	42.1	6.6	18.6
Түлш шатхуун, тослох материал	13.9	12.1	-1.8	-12.9
Барилга засварын материал	2.2	2.7	0.5	22.7
Хүнсний материал	42.7	51.7	9.0	21.1
Бусад хангамжийн материал	478.6	603.8	125.2	26.2
Мал амьтад	102.1	105.0	2.9	2.8
Нөөцийн бараа	61.5	321.2	259.7	422.3
НИЙТ ДҮН	1,576.8	2,087.8	511.0	32.4

Хүснэгтээс харахад: Тусгай зориулалтын бараа материал 18.5 сая, аж ахуйн материал 77.9 сая, бусад хангамжийн материал 125.1 сая, нөөцийн бараа материал

260.0 сая, эм боох материал 2.4 сая, бичиг хэргийн материал 10.2 сая, сэлбэг хэрэгсэл 6.6 сая, барилгын материал 0.5 сая, хүнсний материал 9.0 сая, мал амьтад 2.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, түлш шатхуун, тослох материал 1.8 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 2,255.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба худалдаж авсан 1,900.4 сая, хандив тусламжаар 201.1 сая, шилжүүлж авсан 67.7 сая, бусад хэлбэрээр 86.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 2,004.6 сая төгрөгөөр хасагдсан ба зарцуулсан 1,810.9 сая, шилжүүлсэн 88.7 сая, акталсан 105.0 сая төгрөгөөр тус тус данснаас хасагдсан байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 8% буюу 167.9 сая төгрөг ОНӨААТҮГ, 92% буюу 1,919.9 сая төгрөг төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй байна.

6.2 Бусад эргэлтийн хөрөнгө

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 300.6 төгрөг байсан бөгөөд 233.2 сая төгрөгөөр буурч, эцсийн үлдэгдэл 67.4 сая төгрөг болсон байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн эцсийн үлдэгдлээр ОНХС болон Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн барилгын зураг төсөв, он дамжсан ажлууд бүртгэгдсэн байна. Бусад эргэлтийн хөрөнгийн 11.8% буюу 8.0 сая төгрөг нь аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газарт, 66.2% буюу 44.6 сая төгрөг нь аймгийн ОНХС-д, 22% буюу 14.8 сая төгрөг нь Баянтал сумын ОНХС-д тус тус бүртгэгдсэн байна.

6.3 ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Төсвийн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалын хөдөлгөөний тайлан гаргаагүй, цэцэрлэгийн хүүхдийн хоолны норм нормативыг мөрдөөгүйгээс хоолны зардлыг хэтрүүлэн зарцуулсан, жилийн эцсийн тооллогыг ор нэр төдий хийж гүйцэтгэсэн, тооллогыг огт хийгээгүй, бараа материалын ангиллыг зөрүүтэй тайлагнасан, биетээр байгаа бараа материалыг үнэлж орлогоор бүртгээгүй, хүнсний материалын хадгалалтын горим зөрчигдсөн, стандартын шаардлага хангасан зоорь, агуулах байхгүй зэрэг нийтлэг алдаа, зөрчил илэрсэн байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалын 1 дүгээр хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1.7, заалтуудыг зөрчсөн, АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар бараа материал, бусад эргэлтийн хөрөнгийн данстай холбоотой нийт **257.8** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **64.6** сая төгрөгийн алдаа, зөрчлийг

залруулж, **89.3** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **103.9** сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

ДОЛОО. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР

7.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 29,544.8 сая төгрөг байснаас тайлант онд 0.9% буюу 266.1 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 29,810.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Нийт хөрөнгийн 99.5%-ийг биет хөрөнгө, 0.5%-ийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:


(сая төгрөгөөр)				
Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь
Газар				
Барилга байгууламж	31,697.8	33,274.7	1,576.9	63.2
Тээврийн хэрэгсэл	2,117.7	2,240.5	122.8	4.3
Машин тоног төхөөрөмж	5,350.4	5,115.7	-234.7	9.7
Тавилга эд хогшил	1,227.5	1,272.7	45.2	2.4
Түүх соёлын дурсгалт зүйл	62.3	62.5	0.2	0.1
Дуусаагүй барилга	25.0	25.0	0.0	0.0
Номын фонд	116.2	136.2	20.0	0.3
Зам, гүүрийн байгууламж	3,643.1	3,862.7	219.6	7.3
Биет бус хөрөнгө	443.3	318.3	-125.0	0.6
Бусад үндсэн хөрөнгө	6,121.9	6,360.5	238.6	12.1
ДҮН	50,805.2	52,668.8	1,863.6	100.0

Хүснэгтээс харахад: Нийт үндсэн хөрөнгийн 63.2%-ийг барилга байгууламж, 12.1%-ийг бусад үндсэн хөрөнгө, 9.7%-ийг машин тоног төхөөрөмж, 7.3%-ийг зам гүүрийн байгууламж, 7.7%-ийг бусад хөрөнгүүд тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд 3,100.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 77.3 сая, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,999.1 сая, шилжүүлж авсан 732.9 сая, данснаас дансанд шилжүүлсэн 291.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 1,236.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 52,668.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд 990.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 246.7 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлж, 2,231.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



7.2. Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой тус тайланд нэгтгэгддэг байгууллагуудын аудитаар нийт **168.0** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс аудитын явцад **97.3** сая төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **15.3** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **55.4** сая төгрөгийн зөрчил дутагдал арилгах зөвлөмж өгсөн байна.

Үндсэн хөрөнгийн тайланг улирал бүр гаргаж тайлагнаагүй, эд хариуцагч солигдсон тухай бүр болон хагас, бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийгээгүй, шинээр худалдан санхүүгийн програмыг зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглааагүй үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулсан, үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тооцоолсон, байгууллагаас шилжүүлэн өгсөн хөрөнгийг бүртгэл тайланд дутуу тусгасан, өөрт хамааралгүй үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагад нь шилжүүлээгүй, эрх бүхий албан тушаалтаны шийдвэргүй үндсэн хөрөнгийг данснаас хассан, ОНХС-гаас хийгдсэн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй, дутуу бүртгэх, ашиглагдаж байгаа хөрөнгийн ихэнх нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үнэгүйдсэн хөрөнгө байгаа зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой байна.

Эдгээр нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.6, Сангийн сайдын 2010 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан НББ-ын дансны зааврын 4.32, дахь заалтууд болон АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

НАЙМ. ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ**8.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар:**

Орон нутгийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 469.4 сая төгрөг байснаас тайланд онд 50.2%-иар буюу 933.7 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 1,403.1 сая төгрөг болсон байна.

Өр, төлбөрийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Богино хугацаат зээлийн өглөг	0.2	350.0	349.8	24.9
Ажилчидтай холбоотой өглөг	14.5	5.8	-8.7	0.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2.7	0.0	-2.7	0.0
Байгууллагад өгөх өглөг	419.6	563.3	143.7	40.1
Хүмүүст өгөх өглөг	32.4	4.0	-28.4	0.3
Урьдчилж орсон орлого		480.0	480.0	34.2
Нийт өр төлбөрийн дүн	469.4	1,403.1	933.7	100.0
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	0.0	0.0	0.0	0.0
Төсвийн байгууллага	133.4	914.8	781.4	65.2
Төсөл, сан	218.4	343.6	125.2	24.5
ОНӨААТҮГ-ууд	117.6	144.7	27.1	10.3
НИЙТ ДҮН	469.4	1,403.1	933.7	100.0

Хүснэгтээс харахад: Нийт өглөгийн 40.2%-ийг байгууллагад өгөх өглөг, 24.9%-ийг богино хугацаат зээлийн өглөг, 0.3%-ийг хүмүүсээс өгөх өглөг, 0.4%-ийг ажиллагчидтай холбоотой өглөг, 34.2%-ийг урьдчилж орсон орлого эзэлж байна.

Нийт өглөгийн 65.2% нь төсөвт байгууллагын, 24.5%-ийг төсөл сангийн, 10.3% нь ОНӨААТҮГ-ын өглөг тус тус байна.

Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Нийт өр төлбөр		Зөрүү	Нийт дүнд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	Сүмбэр сум	70.2	92.4	22.2	6.6
2	Баянтал сум	54.7	73.3	18.6	5.2
3	Шивээговь сум	22.1	8.1	-14.0	0.6
4	Говьсүмбэр аймаг	320.1	1,229.3	909.2	87.6
Дүн		467.1	1,403.1	936.0	100.0

Хүснэгтээс харахад: Тайлант онд өглөг нийт 936.0 сая төгрөгөөр өссөн бөгөөд сумдын өр төлбөр 26.8 сая, аймгийн өглөг 909.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аймаг, сумын нийт өр төлбөрт эзэлж байгаа хувь хэмжээг диаграмаар харуулбал:



Диаграммаас харахад: Нийт өр төлбөрийн 87.6%-ийг аймгийн төвийн байгууллагууд, 6.6%-ийг Сүмбэр сум, 5.2%-ийг Баянтал сум, 0.6%-ийг Шивээговь сум эзэлж байна.

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

(сая төгрөгөөр)			
№	Байгууллагуудын төрөл	Эцсийн үлдэгдэл	Нийт дүнд эзлэх хувь
1	Төсөвт байгууллагууд	906.0	64.6
2	Төсөл сан	343.6	24.5
3	Төрийн сан	0.0	0.0
4	Тусгай шилжүүлэгийн байгууллагууд	8.7	0.6
5	ОНӨААТҮГ	144.8	10.3
Дүн		1,403.1	100.0

Хүснэгтээс харахад: нийт өр төлбөрийн 64.6%-ийг төсөвт байгууллагууд, 24.5%-ийг төсөл сан, 10.3%-ийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 0.6%-ийг тусгай шилжүүлгийн байгууллагууд тус тус эзэлж байна.

8.2 Өглөгийн үлдэгдэл, тооцоо нийлэлтийн талаар

8.2.1 Төсөвт байгууллагын өглөгийг тодруулбал:

Төсөвт байгууллагын өглөг 914.8 сая төгрөгөөр тайлагнагдсаны 91.8% буюу 840.4 сая төгрөг нь орон нутгийн байгууллагын, 7.1% буюу 65.6 сая төгрөг нь ОНХС-гийн, 0.9% буюу 8.7 сая төгрөг нь тусгай шилжүүлгийн байгууллагын, 0.2% буюу 0.2 сая төгрөг нь байгаль хамгаалах сангийн өглөг байна.

Орон нутгийн байгууллагын 840.4 сая төгрөгийн өглөг нь 9 байгууллагад, тусгай шилжүүлгийн байгууллагын 8.7 сая төгрөг нь 12 байгууллагад тус тус өгөх өглөг байна.

Төсвийн шууд захирагчид өглөгтэй ажиллаж байгаа нь “Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйг харуулж байна. Аудитаас төсөв захирагч бүрд өглөг барагдуулах талаар арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажилласан болно.

Эдгээр өглөгийг барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлж байсан ч зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээ авдаггүй, анхаардаггүй байсаар өнөөг хүргэсэн бөгөөд энэ жилийн тайланд мөн барагдаагүй, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг нь гэрээний хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй газруудтай холбоотой үүссэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн өглөгийн дүн өмнөх оноос 19.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн өглөгийн 65% буюу 37.7 сая төгрөг нь Сүмбэр сум, 21.5% буюу 14.1 сая төгрөг нь аймгийн ОНХС, 20.9% буюу 13.7 сая төгрөг нь Баянтал сум тус тус эзэлж байна.

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсөл сангийн өглөгийн судалгаанаас үзэхэд өглөгийг барагдуулах ажил удаашралтай, дорвитой арга хэмжээ авч, санал санаачлага гаргахгүй байгаагаас өглөг он дамжин хадгалагдаж, насжилт нэмэгдэн улмаар төлөгдөх найдваргүй болох нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

Иймд аудитаас ОНХС-ийн өглөгийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах талаар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

8.2.2 Төсөл, сангийн өглөгийг тодруулбал:

Төсөл сангийн өглөг нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн болон байгаль хамгаалах сангийн өглөг байна. Үүнээс 343.4 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө, 0.2 сая төгрөг нь Байгаль хамгаалах сангийн өглөг байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн өглөг 343.4 сая төгрөгийн 68.2% буюу 233.9 сая төгрөг нь аймаг, 15.7% буюу 53.9 сая төгрөг нь Сүмбэр сум, 14.2% буюу 49.0 сая төгрөг нь Баянтал сум, 1.9% буюу 6.6 сая төгрөг нь Шивээговь сум тус тус эзэлж байна.

8.2.3 ОНӨААТҮГ-ын өглөгийг тодруулбал:

ОНӨААТҮГ-ын өглөг өмнөх онд 117.4 сая төгрөг байсан бол 2017 онд 144.7 сая төгрөг болж 27.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 137.6 сая төгрөг нь “Ус-Ду” ОНӨААТҮГ, 6.8 сая төгрөг нь “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ, 0.3 сая төгрөг нь “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын үлдэгдэл тус тус байна.

8.3 Урт хугацаат зээлийн талаар:

Урт хугацаат зээлийн өглөгийн эхний үлдэгдэл 796.9 сая төгрөг байснаас тайлант онд 44.6 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 841.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь ОНӨААТҮГ-ын хойшлогдсон татварын өглөгийн дүн байна. Үүнээс 9.5% буюу 80.0 сая төгрөг нь “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ, 90.5% буюу 761.4 сая төгрөг нь “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын өглөг байна.

8.4 Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитаар өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **69.6** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **31.1** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **21.9** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **16.6** сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Өр, төлбөртэй холбоотой гарч байгаа зөрчил дутагдал нь ажиллагсдын цалингаас ХХОАТ, НДШ-ийг суутган тооцсон боловч холбогдох байгууллагуудад шилжүүлдэггүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй өр, төлбөрийг бүртгэж, тайлагнасан, өмнөх оноос өр төлбөрийг нэмэгдүүлсэн, барагдуулах талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй, ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж бүртгэдэггүйгээс өр төлбөрөө буруу тайлагнадаг зэрэг нягтлан бодогчийн ажлын хариуцлагатай холбоотой байна.

Эдгээр нь НББ-ийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4, АОУС “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

ЕС. ОРЛОГЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

9.1 Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд нийт 19,390.7 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүртгэсэн байна. Энэ нь өмнөх оноос 1.9% буюу 391.6 сая төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын бууралтад ОНХС-гийн шилжүүлгийн орлогын бууралт нөлөөлсөн байна.

Үр дүнгийн тайлангаарх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	
			Дүн	Хувь
Татварын орлого	4 798.1	4 718,2	-79,9	-1,7
Татварын бус орлого	4 816.9	5 076,3	259,4	5,4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	919.9	682,4	-237,5	-25,8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2 364.1	3 226,0	861,9	36,5
Бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого	1 036.5	684,5	-352,0	-33,9
ОНӨААТҮГ-ын цэвэр борлуулалт	479.9	483,4	3,5	0,7
Тусгай зориулалтын шилжүүлэг	7 758.4	8 091,6	333,3	4,3
ОНХС-гийн шилжүүлсэн орлого	2 227.4	1 178,1	-1 049,3	-47,1
Санхүүгийн дэмжлэг	16.5	-	-16,5	-100,0
Орон нутгийн санхүүжилтийн орлого	-	4,9	4,9	
Нэмэлт санхүүжилтийн орлого	168.6	321,7	153,1	90,8
Нийт дүн	19 769.3	19 390,7	-391,6	-1,9

/сая төгрөгөөр/

Хүснэгтээс харахад: Орлогын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад татварын орлого, ОНХС-ийн шилжүүлгийн орлогууд тус тус 79.9-1,049.3 сая төгрөг буюу 1.7-47.1%-иар буурч, татварын бус орлого, орон нутгийн санхүүжилтийн болон нэмэлт санхүүжилтийн орлого, ОНӨААТҮГ-ын орлого, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн орлогууд 3.5-333.3 сая төгрөгөөр буюу 0.7-90.8%-иар тус тус нэмэгдсэн байна. Тухайлбал: Татварын бус орлого нийт дүнгээрээ өмнөх оноос өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 36.5% буюу 861.9 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой бөгөөд төсөвт байгууллагын өөрийн орлого, санхүүгийн дэмжлэг, бусад орлого болон зээлийн хүүгийн орлогууд 16.5-352.0 сая төгрөгөөр буюу 25.8-100.0%-иар буурсан үзүүлэлттэй байна.

2017 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй байна.

9.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар:

2017 онд орон нутгийн ТЕЗ-ийн хэмжээнд нийт 16,844.6 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөж, батлуулснаас 16,766.0 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, нийт орлого, санхүүжилтийн төлөвлөгөө 78.5 сая төгрөгөөр тасарсан нь төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь сумдын Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 8,091.6 сая, ОНХС-гийн санхүүжилт 1,178.1 сая, нийт 9,269.7 сая төгрөгийн орлогыг улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг хийхээр төлөвлөж, 100% буюу бүрэн санхүүжсэн байна.

Өмнөх оны тэнцлийн ашиг 1,809.6 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 2,183.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 17,951.0 сая, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр 480.0 сая, санхүүгийн мөнгөн гүйлгээгээр 351.5 сая, нийт 18,782.5 сая төгрөгийн орлого тус тус бүртгэж, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 15,929.5 сая, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр 2,146.4 сая, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 16.4 сая, нийт 18,092.3 сая төгрөгийн зарлага бүртгэж, 2,873.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны орлогыг 17,951.0 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд үүнээс төсөвт байгууллагуудын орлого, санхүүжилт 14,793.0 сая, нэмэлт дансны санхүүжилт 320.2 сая төгрөгөөс бүрдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн орлого нь орон нутгийн төсвөөс 5,246.9 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 7,932.8 сая, ОНХС-гийн санхүүжилт 1,178.1 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 184.5 сая, туслах үйл ажиллагааны орлого 137.8 сая төгрөгөөс тус тус бүрдсэн байна.

Нэмэлт дансны орлого санхүүжилт нь НҮБ-аас 0.8 сая, УИХ-аас 1.2 сая, ХЗДХЯ-наас 3.6 сая, БХЯ-наас 2.4 сая, БСШУСЯ-наас 10.5 сая, ЭМЯ-наас 1.1 сая, Засаг газрын нөөц хөрөнгөнөөс 180.0 сая, аймгийн БСГ-аас 31.8 сая, ЭМГ-аас 8.0 сая,

архивын ажилчдын цалин 8.1 сая, ГХГЗЗГ-аас 3.0 сая, Ойн судалгаа хөгжлийн төв 13.1 сая, ГБХЗХГ-аас 23.9 сая, барилга хөгжлийн төв 2.9 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 29.6 сая, нийт 320.3 сая төгрөгийг тус тус хүлээн авч бүртгэсэн байна.

2017 онд орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 4,508.6 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 5,269.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 16.9% буюу 761.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаар 5,269.8 сая төгрөг, аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр 5,274.9 сая төгрөгөөр тооцож, 5.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь өмнөх онуудын татварын орлогоос буцаан олгуулахаар гарсан шүүхийн шийдвэрийн дагуу иргэдэд олгосон бөгөөд аймгийн Татварын хэлтсээс тайлант оны орлоготой холбоогүй гэж үзэн хасаж тооцоогүйтэй холбоотой байна.

Тайлант оны орон нутгийн орлогоос 268.8 сая төгрөгийн ХХОАТ-ын буцаан олголт хийгдсэн байна.

Тайлант онд орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг аймаг болон сумдаар дараах хүснэгтээр харуулбал:

Д/д	Аймаг, сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Сүмбэр сум	215,3	353,9	138,7	0,64
2	Баянтал сум	17,9	15,9	- 2,0	- 0,11
3	Шивээговь сум	56,4	64,0	7,6	0,13
4	Говьсүмбэр аймаг	4 218,9	4 835,9	616,9	0,15
Нийт дүн		4 508,6	5 269,8	761,2	0,17

/сая төгрөгөөр/

Хүснэгтээс харахад: орон нутгийн орлогын төлөвлөгөө Баянтал сум 11.0% буюу 2.0 сая төгрөгөөр тасалж, аймаг болон Сүмбэр, Шивээговь сум 13.0-64.0% буюу 7.6-616.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

9.3 Бусад эх үүсвэрийн талаар:

Орон нутгийн орлогоос гадна төсөвт зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орлогын бусад эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Аймаг, сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Санхүүгийн дэмжлэг			-	
Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	1 178,08	1 178,08	-	-
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	8 091,62	8 091,62	-	-
Тэнцлийн ашиг	1 809,55	1 809,55	-	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1 256,73	416,93	-839,80	- 0,67
Нийт дүн	12 335,99	11 496,19	-839,80	- 0,67

Хүснэгтээс харахад: төсөвт байгууллагын өөрийн орлогоос бусад эх үүсвэрүүд бүх нэр төрлөөрөө төлөвлөгөөний дагуу бүрэн санхүүжигдсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө их хэмжээгээр тасарсан нь сумдын Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлогыг төсвийн төлөвлөгөөнд оруулж төлөвлөдөг болсонтой холбоотой байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүний бүртгэл тайлагналтай холбоотой нийт **20,286.9** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **18,346.9** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **1,940.0** сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 11.0% буюу **2,244.1** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 89.0% буюу **18,042.8** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үйл ажиллагааны орлогын дүнг аудитлагдсан тайлангаас 17,049.2 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

- Аймгийн ЗДНС-гаас зарцуулсан наадмын зардлаас буцаан төвлөрүүлсэн 2.1 сая төгрөгийн үлдэгдлийг АЗДТГ-т өөрийн орлогоор тус тус давхар бүртгэгдсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид орлогыг давхардуулан бүртгэхгүй байх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн батлуулаагүйгээс ТТАМНАТ-ийн орлогын төлөвлөгөө 67.1% буюу 3.1 сая, сумдын Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангийн орлогын төлөвлөгөө нийт 90.0% буюу 949.4 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө тасарсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж батлуулах, батлагдсан орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

- Шивээговь сумын 3 дугаар сургууль, 3 дугаар цэцэрлэгийн ахмадын сангийн 4.6 сая, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-т Сүмбэр сумын ОНХС-гаас хийгдсэн

ажлын санхүүжилт 9.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус давхардуулан тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

- Данснаас дансанд шилжүүлсэн 25.4 сая төгрөгийн хөрөнгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

Аудитын явцад орлогын бүрдүүлэлт, бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчил дутагдал нь орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй, үйл ажиллагааны орлогыг бүртгээгүй, шууд зарцуулах, сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү, алдангийн орлогыг дутуу тайлагнах, батлагдсан төсвөөс илүү санхүүжилт олгосон, өмнөх оны үлдэгдлийг зөрүүтэй тайлагнах, буцаан төвлөрүүлсэн болон нэмэлт дансаар дамжуулсан орлогыг давхардуулан бүртгэх, банкны үйлчилгээний хураамжийг орлогоор бүртгээгүй зэрэг зөрчил дутагдлууд гарсантай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 41 дүгээр зүйлийн 41.2-т, 41.2.1 дэх заалтуудыг зөрчиж байна.

АРАВ. ЗАРДЛЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

10.1. Санхүүжилтийн зарцуулалтын талаар:

Аймгийн 2017 оны төсвийн нийт зарлага 16,844.5 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс **14,733.5** сая төгрөгийн буюу 87.4%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн нийт зарлага 8,700.2 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6,741.2 сая төгрөгийн буюу 77.4%, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага 8,144.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс **7,992.3** сая төгрөгийн буюу 98.1%-ийн гүйцэтгэлтэй байна.

2017 онд орон нутгийн ТЕЗ-ийн төсвийг өмнөх оны гүйцэтгэлээс 37.3 сая төгрөгөөр бууруулж, нийт 16,844.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, баталсан ба 14,733.5 сая төгрөг зарцуулж, 2,111.0 сая төгрөгийн хэмнэлттэй мэт харагдаж байгаа боловч төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 839.8 сая төгрөгөөр тасарсанаас зарлага санхүүжилт хийгдээгүй бөгөөд бодит хэмнэлт гэж үзэх үндэслэлгүй байна.

Төсвийн гүйцэтгэл төлөвлөгдсөнөөс нийт 2,047.8 сая төгрөгөөр зарцуулагдаагүй үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээр төлөвлөрүүлсэн 111.9 сая,
- Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гаргаагүй 0.2 сая,

- Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлээгүйгээс дутуу санхүүжсэн 2.0 сая,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн болон орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гараагүй нийт 158.8 сая
- ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл 675.8 сая
- СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс зээл олголт 934.8 сая төгрөгийн зарлагын санхүүжилт хийгдээгүй
- Халамжийн сангийн гүйцэтгэл төлөвлөгдсөнөөс 164.3 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан зэргээс тус тус шалтгаалжээ.

10.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар:

Тайлант онд ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагууд 320.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ. Үүний 73.6%-ийг орон нутгийн төсвийн байгууллагууд, 11.5%-ийг Боловсрол, соёл, урлагийн салбарын байгууллага, 7.5%-ийг Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, 2.9%-ийг Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 4.5%-ийг ГХБХБГ зарцуулжээ.

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нэмэлт санхүүжилт
Орон нутгийн төсвийн байгууллагууд	235.8
Боловсрол, соёл, урлагийн байгууллага	36.8
Эрүүл мэндийн салбарын байгууллага	9.2
Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар	23.9
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	14.5
Нийт дүн	320.2

10.3 Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **1,315.0** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **708.3** сая төгрөгийн алдаа, зөрчлийн залруулга хийж, **12.7** сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, **27.0** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **567.0** сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 85.0% буюу **1,118.5** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 15.0% буюу **196.5** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ Үүнд:

- Данснаас дансанд шилжүүлсэн 25.4 сая төгрөгийн хөрөнгийг үр дүнгийн тайланд зарлагаар бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

- Аймгийн хэмжээнд анх 14,735.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, 2 удаагийн төсвийн тодотголоор 2,109.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 16,844.5 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Төсвийн тодотголоор цалингийн зардлыг 91.7 сая, урсгал засвар 40.6 сая, сурталчилгааны зардал 0.5 сая, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг 36.4 сая, бичиг хэргийн зардлыг 0.4 сая, уралдаан тэмцээний зардлыг 1.5 сая, нийт 171.1 сая төгрөгөөр тодотгож төсвийг үндэслэлгүй нэмэгдүүлэн баталж, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой дараах нийтлэг зөрчил дутагдал илэрсэн байна. Тухайлбал: ээлжийн амралтын мөнгийг буруу тооцоолсноос цалинтай давхардуулан олгосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нэмэгдэл, урамшуулал олгох, албан томилолтын зардлыг илүү, дутуу тооцож олгох, данснаас дансанд хөрөнгө шилжүүлэхдээ зардлаар тайлагнасан, тоон мэдээллийг давтан тооцоолдоггүй, хянах үйл ажиллагаа хангалтгүйгээс зөрүүтэй тайлагнасан, аудитлагдсан тайланг зөрүүтэй нэгтгэсэн, ОНХС-ийн болон хөрөнгийн зардлаас дэд хөтөлбөр нэрээр урсгал зардлуудыг санхүүжүүлэх, зардлын зүйл ангийг буруу ангилж бүртгэх, нөөц сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах зэрэг алдаа зөрчлүүд илэрсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.6.2, 6.3.2, 6.4.1, 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, ХХОАТ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1, энэ хуулийн 135 дугаар зүйлийн 135.1.3, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1, Засгийн газрын 207 оны 354 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2000 оны 166 дугаар тогтоолын 13, Сум хөгжлийн сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” зэрэг хууль эрх зүйн актуудыг тус тус зөрчсөн байна.

АРВАН НЭГ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ЗӨРЧЛҮҮДИЙН ТАЛААР:

Аудитаар орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн алдаа, зөрчлүүдийн ихэнх хувийг нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой зөрчил дутагдал эзэлж байна. Үүнд:

- Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлдэггүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн
- Ажилчдын ээлжийн амралтын цалинг, цалинтай давхардуулан олгосон
- Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалыг зөрчсөн
- Бараа материалын зарлагыг өөр зардлын нэрээр ангилал зөрүүтэй тайлагнасан

- Гэрээний гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд хэсэгчлэн бүртгэж тайлагнасан
- Гэрээт ажлын цалингаас бараа материал бэлтгэж, зориулалт бусаар зарцуулан цалингийн зардлаар тайлагнасан
- Хөрөнгийн дансны ангилал, нэр төрлийг буруу бүртгэж тайлагнасан
- Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцсон татварын орлогыг хүүгийн орлогоор бүртгэж тайлагнасан байна
- Санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, аудитад саад учруулсан
- Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл баталгаажаагүй
- Санхүүгийн байдлын тайланг зөрүүтэй бэлтгэсэн
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн
- Мөнгөн гүйлгээний тайлангийн болон үр дүнгийн тайлангийн орлого, зарлагыг зөрүүтэй бүртгэсэн
- Арилжааны банкны дансаар гүйлгээ хийгдсэн зээл, хөрөнгө оруулалт, хүүгийн орлогыг дутуу бүртгэсэн
- Мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг бүртгээгүй
- Арилжааны банкин дахь бэлэн мөнгөний дансаар хууль тогтоомж зөрчин орлого бүртгэж зарцуулсан
- Арилжааны банкны дансны үлдэгдлийг бүртгэж тайлагнаагүй
- Өмнөх оны аудитлагдсан тайлангуудыг зөрүүтэй тайлагнасан
- Дотоод хяналт сул байгаагаас залилан мэхлэх, хөрөнгө шамшигдуулах ажил гүйлгээ хийж гүйцэтгэсэн
- Эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан шаардлагын дагуу үнэн зөв хийж гүйцэтгээгүй
- Ажил гүйлгээг өглөг, авлагын дансаар дамжуулан бүртгэдэггүй, өглөг, авлагыг бууруулж ажиллаагүй.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **3,260.9** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **1,224.6** сая төгрөгийн алдаа, зөрчлийн залруулга хийж, **1,333.3** сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгч, **703.0** сая төгрөгийн алдаа залруулагдаагүй байна.

АРВАН ХОЁР. ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн тайланд өмнөх үеийн үр дүн 8,684.4 сая төгрөг байсан ба тайлант онд 3.0 сая төгрөгийн нэмэлт өөрчлөлтөөр буурч, тайлант онд 732.0 сая төгрөгийн үр дүнтэй ажилласнаар хуримтлагдсан үр дүн 9,413.4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

АРВАН ГУРАВ.ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ТАЛААР

13.1 Орон нутгийн төсвийн эзэмшигчийн өмч

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн ЗГ-ын капитал/орон нутгийн сан/ 2016 оны эцэст 19,527.1 сая төгрөг байсан бол тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын хувь оролцооны бүтэц

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,527.2	19,527.2	0.0
Өмч /төрийн/	19,527.2	19,527.2	0.0
Нэмж төлөгдсөн капитал	0.0	0.0	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	326.2	326.2	0.0
Хуримтлагдсан үр дүн	8,684.4	9,416.5	732.1
Өмнөх үеийн үр дүн	6,997.5	8,684.4	1,686.9
Тайлант үеийн үр дүн	1,686.9	732.1	-954.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,356.5	5,356.5	0.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.0
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		-3.0	-3.0
Засгийн газрын хувь оролцоо	33,894.3	34,623.4	729.1

Хүснэгтээс харахад: тайланд онд засгийн газрын хувь оролцоо нийт 729.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд онд 732.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан ба байгууллагуудын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал дутуу тооцогдсноос өмнөх үеийн үр дүнд 3.0 сая төгрөгийн залруулга хийгдэж хасагдсан байна.

13.2 Дахин үнэлгээний нөөцийн талаар

2016 оны эцэст хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 5,356.4 сая төгрөг байсан бол тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

**АРВАН ДӨРӨВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ДҮН**

14.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитаар нийт **188.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад **30.0** сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, хариуцлага тооцуулах 1 санал хүргүүлж материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах **158.6** сая төгрөгийн 10 зөвлөмж өглөө.

Тайлант хугацаанд 3 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, 2 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, 1 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд: Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн байна.

14.2 Орон нутгийн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан хуваарийн дагуу 2017 онд орон нутгийн ТЭЗ-ийн харъяа байгууллагуудын хэмжээнд төсвийн шууд захирагчийн нийт 34 байгууллагыг хамруулан аудит хийснээс орон нутгийн төсвийн байгууллагын 14,

Эрүүл мэндийн салбарын байгууллага 3, боловсролын салбарын 14, ГХБХБС-ын 1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын 1, БОАЖС-ын 1 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгсөн байна.

Орон нутгийн 34 шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,858.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 1,675.3 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 636.9 сая төгрөгийг залруулагдаагүй алдаагаар тооцож, 23.6 сая төгрөгийн зөрчилд 22 акт тогтоож, 38.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 6 санал хүргүүлж, 66.0 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 418.6 сая төгрөгийн 58 зөвлөмж өглөө.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 23, “Хязгаарлалттай” 2, “Сөрөг” 2 санал дүгнэлт өгч, 2 санхүүгийн тайланд “санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” болно. Үүнд: Аймгийн Боржигин чуулга, Шивээговь сумын ИТХ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Баянтал сумын 4-р сургуулийн санхүүгийн тайланд “Сөрөг”, Баянтал сумын 4-р Цэцэрлэг, Сумын дундын ойн ангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

14.3 Тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитаар нийт 2,732.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 225.5 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 17.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 санал хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 2,488.8 сая төгрөгийн 13 зөвлөмж өглөө.

Аудитад нийт 16 санг хамруулснаас 4 санд “зөрчилгүй”, 1 санд “хязгаарлалттай” дүгнэлт гаргаж, 11 санг түүвэрт хамрууллаа.

14.4 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитаар нийт 2,758.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 2,627.4 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 2.1 сая төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 112.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 16.9 сая төгрөгийн 8 зөвлөмж өглөө.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ болон холбогдох журмыг зөрчсөн, ББӨ-ийг үнэн зөв тооцоогүй, он дамжсан авлага, өглөгийг барагдуулж ажиллаагүй зэрэг нийтлэг алдаа, зөрчил гаргасан байна.

Аудитад нийт 5 орон нутгийн өмчит хуулийн этгээд хамрагдахаас бүрэн хамрагдаж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

АРВАН ТАВ. ОРОН НУТГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ:

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт **26,981.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад **21,671.9** сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, **26.3** сая төгрөгийн зөрчилд 26 акт тогтоож, **168.5** сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 8 санал хүргүүлж, **703.0** сая төгрөгийн алдааг залруулаагүй бөгөөд зөрчил, дутагдлыг арилгах **4,411.3** сая төгрөгийн 91 зөвлөмж өглөө.

Нийт зөрчил дутагдлын 31.6% буюу **8,538.6** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 68.4% буюу **18,442.4** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нийт 58 байгууллагын санхүүгийн тайланг хамруулсанаас 2 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 14 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 34 байгууллагад “зөрчилгүй”, 3 байгууллагад “хязгаарлалттай”, 3 байгууллагад “сөрөг” санал дүгнэлт өгч, 2 байгууллагад “дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна. Нийт байгууллагын 13.7% буюу 8 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай, сөрөг, татгалзсан дүгнэлт өгсөн байна.

АРВАН ЗУРГАА: ӨМНӨХ ОНЫ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 3 нь бүрэн хэрэгжиж, зөвлөмжийн хэрэгжилт 60%-тай байна.

Халамжийн сангийн төсвийг бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөх, арилжааны банкуудтай ажлын уялдаа холбоогоо сайжруулах, хяналтын чиг үүргээ зохистой хэрэгжүүлж, ажиллах талаар өгсөн 2 зөвлөмж хэрэгжээгүй байна.

АРВАН ДОЛОО. ОРОН НУТГИЙН ТЕЗ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулга нь холбогдох хууль тогтоомж, УСНББОУС болон тэдгээрт нийцүүлэн Сангийн сайдын баталж гаргасан заавар, журмуудын дагуу бэлтгэгдэж, материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь орон нутгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг хүсье.

3.1 Төсвийн төлөвлөлтийн талаар

Илрүүлэлт

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн батлуулаагүйгээс ТТАМНАТ-ын орлогын төлөвлөгөөг 67.1%, сумдын Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангийн орлогын төлөвлөгөөг 90.0%-иар тус тус дутуу төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг тасалсан, мөн Халамжийн сангийн төсвийг үндэслэлгүй өндөр төлөвлөснөөс өмнөх онд **281.8 сая**, тайлант онд **164.3** сая төгрөгийн хэмнэлт үүсч төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга Г.Батсуурь
Ерөнхий нягтлан бодогч Б.Соёлмаа

Зөвлөмж

Татварын орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж батлуулах, батлагдсан орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах

Халамжийн сангийн төсвийг бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөж, зөрчигдсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Эрсдэл

Төсвийг зохистой төлөвлөж, удирдах зарчим алдагдах, орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө тасрах эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Дээрх зөвлөмжийг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан болно.

3.2 Төсвийн зардлын талаар

Илрүүлэлт

Төсвийн тодотголоор тэвчиж болох зардлуудыг тодотгож, 171.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Аймгийн Баяр наадмыг тэмдэглэхэд АОНХС-гаас 20.0 сая, АЗДНС-гаас 21.5 сая, нийт 41.5 сая төгрөгийг зарцуулж, арга хэмжээний зардлыг 31.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын нөөц сангаас 2018 оны төсөв, төлөвлөгөө батлахтай холбоотойгоор ИТХТ-ийг хүлээн авч уулзалт зохион байгуулахад 2.0 сая аймагт Өмгөөлөх алба байгуулагдсаны 25 жилийн ойн баярыг тэмдэглэхэд дэмжлэг 0.3 сая, Монголын ҮЭ-ийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг 5.0 сая, нийт 7.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, МУЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын 1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолуудыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Аймгийн Засаг дарга Г.Батсуурь
Ерөнхий нягтлан бодогч Б.Соёлмаа

Эрсдэл

Шийдвэр гаргасан албан тушаалтан хариуцлага хүлээх эрсдэлтэй

Зөвлөмж

Төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх

Хууль эрхийн актаар тогтоосон хэм хэмжээг баримтлан ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Дээрх зөвлөмжийг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан болно.

3.3 Авлага, өглөгийг барагдуулах талаар**Илрүүлэлт**

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 1,655.7 сая төгрөгийн авлага, 1,403.1 сая төгрөгийн өглөгийг тус тус үлдэгдлээр тайлагнасан байна.

